

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянцагаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/16/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2023.03.25	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Б.Нарангэрэл Утас: 99009293 Цахим хаяг: Narangerelb@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ 7	
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	17
3.4.1 Мөнгөн хөрөнгө.....	18
3.5.2 Авлага.....	18
3.5.4 Бараа материал	19
3.5.6 Үндсэн хөрөнгө	20
3.5.7 Өр төлбөр	21
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо.....	21
3.5.11 Орлогын данс.....	22
3.5.12 Зардлын данс.....	22
Хүснэгт 18: Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	26
4. АУДИТЫН ТАЙЛАН	28
4.1 Ерөнхий зүйл	28
4.2 Материаллаг байдал.....	29
4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	29
4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	30
4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	30
4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	30
4.7.1 Завсрын аудитын талаар	30
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	31
5.1 Албан шаардлага.....	31
5.2 Зөвлөмж.....	31

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2023.03.25 № д/133
танай _____-ны № _____-т

БАЯНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Н.ГАНСҮХ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Баянцагаан сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянцагаан сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Харьяа төсөвт байгууллагуудын аудитаар илэрсэн зөрчил нь төлөвлөлтийн шатанд урьдчилан тогтоосон материаллаг байдлаас хэтэрсэн бөгөөд бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газар
 - Тайлант хугацааны нярвын тайлан нь санхүүгийн тайлангаас 26,519.8 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн;
 - Шатахууныг зориулалт бусаар зарцуулсан;
 - Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж өмнөх оноос албан томилолт, тээвэр шатахуун, бичиг хэргийн зардлыг нэмэгдүүлсэн;
- Баянцагаан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал
 - Шатахууныг зориулалт бусаар зарцуулсан;
 - Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж бүсчилсэн сургалт зохион байгуулсан;
- Баянцагаан сумын Орон нутгийн хөгжлийн сан
 - ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 189,404.7 мянган төгрөгийн өртөг бүхий Цэцэн 3 дугаар багийн төвийн засварын ажлын гүйцэтгэгч компанийн гэрээний үүргийн биелэлтэд хяналт хэрэгжүүлээгүй,
 - ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг гүйцэтгэгч иргэн аж ахуйн нэгж байгууллагаас зураг төсвийн үнийг суутган тооцоогүй;

D- alban bichig 2022 A4 TOOT

005020504

- ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг санхүүгийн тайланд бүртгээгүй, зураг төсвийн үнийг авлагаар тусгаагүй;
1. Баянцагаан сумын Засаг дарга
- Сумын төсөвт төвлөрөх татварын орлогоос газрын төлбөр 1627.9 мянга, хог хаягдлын үйлчилгээний төлбөр 18,525.1 мянга, малын тоо толгойн албан татварын орлого 41,599.9 мянган төгрөгөөр тасарсан байна.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1."Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 "Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх", Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 9.15 "Барилга байгууламж болон их засварын ажлын төсөвт өртөгт барилгыг үнэ бүрдлийн дүрэмд тусгасны дагуу зохиогчийн хяналтын зардал, захиалагчийн хяналт, магадалшгүй ажил, нэмэгдсэн өртгийн албан татвар, зураг төсөл, хайгуулын зардал, барилга байгууламжийн норм, нормативын сангийн шимтгэл гэх мэт нэг бүрчлэн төсвийн зардлыг тооцно", 9.17 "Зураг төсөл боловсруулсан зардал, зохиогчийн болон захиалагчийн хяналтын зардлыг тухайн төсөл дээр байгуулсан гэрээ, хийсэн ажлын тайлангийн дагуу холбогдох норм дүрэмд заасныг үндэслэн энэ журмын Хавсралт №16-д заасан маягыг бөглөж олгоно" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн санхүүгийн тайлангийн "Оршин байх", "Тохиолдсон байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Тайлант онд төсвийн шинэчлэлтэй холбоотойгоор ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн санхүүгийн тайлан Боловсролын ерөнхий газарт, эрүүл мэндийн төвийн тайлан Эрүүл мэндийн яаманд, соёлын төвийн тайлан Соёлын яаманд нэгтгэгдэж, тайланд хөрөнгийг шилжүүлэн бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын дүгнэлтийн үндэслэл болгосон дээрх зөрчил дутагдал нь бидний урьдчилан тогтоосон материаллаг байдлаас хэтэрсэн, аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалтыг ажил гүйлгээний хувьд хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Төсвийн шинэчлэлтэй холбоотой нийт 5,128,294.0 мянган төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр балансаас баланст шилжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Сумын хөгжлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 110 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 84.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

D- alban bichig 2022 A4 TOOT

Баянцагаан сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Сумын Засаг дарга санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

D- alban bichig 2022 A4 TOOT

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	865,537.2	1,285,245.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	288,222.5	789,754.4
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	288,222.5	789,754.4
31210	Төгрөг	288,222.5	789,754.4
31211	Төрийн сангийн харилцах	288,222.5	789,754.4
33	АВЛАГА	280,004.2	217,965.1
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	615.0	0.0
33300	Татаас, санхүүжилтийн авлага	106,299.0	0.0
33500	Бусад авлага	32,356.3	13,141.5
33510	Байгууллагаас авах авлага	21,000.0	10,026.5
33520	Хувь хүмүүсээс авах авлага	11,356.3	3,115.0
33600	Зээлийн авлага	140,734.0	204,823.6
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	140,734.0	204,823.6
33612	Хувь хүмүүст олгосон зээл	140,734.0	204,823.6
35	БАРАА МАТЕРИАЛ	297,310.4	277,526.4
35100	Түүхий эд материал	64,520.9	11,688.0
35110	Тусгай зориулалттай материал	51,072.5	11,688.0
35130	Эм боох материал	13,448.4	0.0
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	57,063.5	235,671.5
35400	Хангамжийн материал	170,226.0	5,166.9
35410	Бичиг хэргийн материал	4,387.7	958.3
35420	Аж ахуйн материал	101,652.5	0.0
35440	Түлш, шатах тослох материал	4,775.8	0.0
35450	Барилгын засварын материал	2,899.3	0.0
35460	Хүнсний материал	19.6	0.0
35470	Бусад хангамжийн материал	56,491.1	4,208.6
35600	Мал амьтад	5,500.0	25,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,445,693.7	1,388,163.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,445,693.7	1,388,163.2
39200	Биет хөрөнгө	5,373,148.2	1,352,731.2
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,161,246.9	2,260,684.4
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,607,316.5	-1,329,581.7
39203	Авто-тээврийн хэрэгсэл	256,300.7	201,514.2
39204	Хуримтлагдсан элэгдэл	-95,627.4	-101,014.3
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	708,367.6	147,838.8
39206	Хуримтлагдсан элэгдэл	-435,012.5	-85,309.9
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	238,899.6	42,382.5
39208	Хуримтлагдсан элэгдэл	-158,297.2	-31,251.9
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	106.3	0.0
39214	Бусад үндсэн хөрөнгө	389,759.5	364,908.7
39215	Хуримтлагдсан элэгдэл	-118,810.6	-119,200.9
39217	Ном	33,531.8	1,761.3
39300	Биет бус хөрөнгө	72,545.5	35,432.0
39301	Програм хангамж	1,430.0	475.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,292.5	-475.0
39303	Бусад биет бус хөрөнгө	72,858.0	35,432.0
39304	Хуримтлагдсан элэгдэл	-450.0	0.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,311,230.9	2,673,409.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	23,489.1	3,115.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	23,489.1	3,115.0
41300	Өглөг	23,489.1	3,115.0
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	12,132.8	0.0
41360	Бусад өглөг	11,356.3	3,115.0
41361	Байгууллагад төлөх өглөг	11,356.3	3,115.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,287,741.8	2,670,294.2
51	Засгийн газрын хувь оролцоо	6,287,741.8	2,670,294.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,453,683.7	511,503.9
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,453,683.7	511,503.9
51200	Хуримтлагдсан үр дүн	1,811,930.4	1,879,168.8
51210	Өмнөх үеийн үр дүн	1,587,628.5	5,391,476.8
51220	Тайлант үеийн үр дүн	224,301.8	-3,512,308.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,022,127.7	279,621.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,311,230.9	2,673,409.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,801,591.6	2,502,239.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	122,170.6	762,920.5
110	Орлогын албан татвар	80,041.8	223,711.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	80,041.8	223,711.1
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	0.0	166,536.5
110002	Үйл ажиллагааны орлого	15,067.4	7,704.8
110003	Хөрөнгийн орлого	58,968.9	47,669.3
110004	Хөрөнгө борлуулсны орлого	6,005.5	1,800.5
113	Хөрөнгийн албан татвар	4,395.0	96,554.9
113002	Бууны албан татвар	4,395.0	4,860.0
113004	Малд ногдуулах албан татвар	0.0	91,694.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	37,733.7	442,654.4
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	36,817.5	26,370.0
118001	Улсын тэмдэгтийн хураамж	1,905.1	13,764.6
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	20.0	0.0
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	34,892.4	12,605.3
1181	Газрын төлбөр	916.2	1,772.0
118101	Газрын төлбөр	916.2	1,772.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	0.0	414,512.5
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0.0	400,678.8
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.0	13,833.7
1183	Бусад татвар	0.0	0.0
118301	Бусад татвар	0.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	451,535.0	227,634.3
120	Нийтлэг татварын бус орлого	451,535.0	227,634.3
120003	Торгуулийн орлого	7,375.0	6,405.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	27,581.1	102,827.3
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	26,901.1	101,015.6
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	680.0	1,811.7
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	313,306.0	87,458.1
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	103,272.9	30,944.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,227,886.1	1,511,684.6
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,924,585.0	47,151.7
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	47,151.7
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,924,585.0	0.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	412,230.1	10,500.4
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	199,030.6	9,200.4
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,000.0	1,300.0
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	212,199.5	0.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	842,028.4	1,454,032.5
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.0	530,260.6
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	646,624.7	516,273.4
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	195,403.7	407,498.5
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	49,042.7	0.0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	49,042.7	0.0

Баянцагаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,537,763.7	1,784,169.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,537,763.7	1,784,169.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,286,147.0	764,571.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,764,283.6	268,368.1
210101	Үндсэн цалин	1,352,898.2	266,568.3
210102	Нэмэгдэл	286,708.3	0.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,927.1	0.0
210104	Урамшуулал	117,750.0	1,799.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	227,523.3	33,822.8
210201	Тэтгэврийн даатгал	162,109.9	23,395.7
210202	Тэтгэмжийн даатгал	16,473.1	2,643.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,509.8	1,966.1
210204	Ажилгүйдлийн даатгал	3,180.0	527.5
210205	Эрүүл мэндийн даатгал	33,250.4	5,290.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	246,456.6	23,862.2
210301	Гэрэл, цахилгаан	18,109.7	6,914.0
210302	Түлш, халаалт	226,219.8	16,948.2
210303	Цэвэр, бохир ус	2,127.2	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	180,269.5	66,331.6
210401	Бичиг хэрэг	6,909.0	4,832.2
210402	Тээвэр, шатахуун	51,147.1	28,272.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,410.0	1,457.8
210404	Ном, хэвлэл	949.5	0.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	30,836.2	29,185.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,262.4	300.0
210408	Бараа материал акталсны зардал	19,744.6	2,283.4
210409	Бараа материал шилжүүлсний зардал	53,010.8	0.0
2105	Нормативт зардал	147,975.2	0.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	73,568.6	0.0
210502	Хоол, хүнс	72,559.4	0.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,847.2	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,724.9	2,650.0
210604	Урсгал засвар	33,724.9	2,650.0
2107	Томилолт, зочны зардал	7,235.5	7,252.0
210702	Дотоод албан томилолт	7,235.5	7,252.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	299,336.5	167,804.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	292,665.1	162,549.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,800.0	500.0
210803	Даатгалын үйлчилгээ	562.6	587.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	99.1	335.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	102.0	110.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,035.0	3,564.0
210807	Газрын төлбөр	72.8	108.9
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.0	48.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	379,341.8	194,480.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,304.8	44,132.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,169.0	2,705.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	339,868.0	147,643.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	251,616.7	1,019,598.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	216,868.0	53,124.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,579.6	30,992.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	47,218.1	19,377.8
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	95,017.4	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	38,052.9	2,754.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	257.7	966,474.6
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	0.0	939,658.3
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	26,816.2
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	257.7	0.0

Баянцагаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	34,490.9	0.0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,490.9	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	263,828.0	718,069.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	39,526.2	4,230,377.7
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	38,316.1	0.0
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,210.1	0.0
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	0.0	4,002,945.1
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	0.0	227,432.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	224,301.8	-3,512,308.0

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,168,230.9	1,694,940.2	669,193.4	4,532,364.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	285,452.9	328,014.4	918,435.1	1,531,902.4
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,453,683.7	2,022,954.6	1,587,628.5	6,064,266.9
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	-826.9	0.0	-826.9
9	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	224,301.8	224,301.8
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,453,683.7	2,022,127.7	1,811,930.4	6,287,741.8
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,453,683.7	2,022,127.7	1,811,930.4	6,287,741.8
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,942,179.8	-1,742,506.3	3,181,018.8	-503,667.3
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	511,503.9	279,621.5	4,992,949.2	5,784,074.6
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-3,512,307,976.30	-3,512,307,976.30
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	511,503,907.78	279,621,466.50	1,879,168,805.91	2,670,294,180.19

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,394,322.8	1,788,976.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	122,170.6	762,920.5
110	Орлогын албан татвар	80,041.8	223,711.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	80,041.8	223,711.1
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	0.0	166,536.5
110002	Үйл ажиллагааны орлого	15,067.4	7,704.8
110003	Хөрөнгийн орлого	58,968.9	47,669.3
110004	Хөрөнгө борлуулсны орлого	6,005.5	1,800.5
113	Хөрөнгийн албан татвар	4,395.0	96,554.9
113002	Бууны албан татвар	4,395.0	4,860.0
113004	Малд ногдуулах албан татвар	0.0	91,694.9

Баянцагаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
118	Бусад татвар, төлбөр, хураамж	37,733.7	442,654.4
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	36,817.5	26,370.0
118001	Улсын тэмдэгтийн хураамж	1,905.1	13,764.6
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	20.0	0.0
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	34,892.4	12,605.3
1181	Газрын төлбөр	916.2	1,772.0
118101	Газрын төлбөр	916.2	1,772.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	0.0	414,512.5
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0.0	400,678.8
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.0	13,833.7
1183	Бусад татвар	0.0	0.0
118301	Бусад татвар	0.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	150,565.1	71,447.8
120	Нийтлэг татварын бус орлого	150,565.1	71,447.8
120003	Торгуулийн орлого	7,375.0	6,405.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	143,190.1	65,042.8
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	142,510.1	63,231.1
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	680.0	1,811.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,121,587.1	954,607.8
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,924,585.0	20,335.5
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	20,335.5
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,924,585.0	0.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	305,931.1	10,500.4
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	123,394.6	9,200.4
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,000.0	1,300.0
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	181,536.5	0.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	842,028.4	923,771.9
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	646,624.7	516,273.4
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	195,403.7	407,498.5
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	49,042.7	0.0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	49,042.7	0.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,081,753.3	951,187.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,081,753.3	951,187.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,820,136.6	877,727.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,772,308.1	318,208.0
210101	Үндсэн цалин	1,351,115.1	265,671.4
210102	Нэмэгдэл	286,976.9	0.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,927.1	0.0
210104	Урамшуулал	127,289.1	1,773.4
210105	Гэрээт ажлын хөлс	0.0	50,763.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	230,327.5	40,150.5
210201	Тэтгэврийн даатгал	164,862.1	27,873.7
210202	Тэтгэмжийн даатгал	16,486.1	3,067.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,764.2	2,445.4
210204	Ажилгүйдлийн даатгал	3,182.6	624.6
210205	Эрүүл мэндийн даатгал	33,032.4	6,139.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	250,731.4	253,910.7
210301	Гэрэл, цахилгаан	18,109.7	19,569.2
210302	Түлш, халаалт	230,494.6	230,044.9
210303	Цэвэр, бохир ус	2,127.2	4,296.7
2104	Хангамж, бараа материалын зардал	117,582.5	64,220.3
210401	Бичиг хэрэг	7,303.7	4,512.2
210402	Тээвэр, шатахуун	50,387.1	28,000.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,410.0	1,457.8
210404	Ном, хэвлэл	1,549.5	0.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	30,836.2	29,649.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,096.1	600.0
2105	Нормативт зардал	137,156.4	0.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	43,589.2	0.0
210502	Хоол, хүнс	72,579.0	0.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	20,988.2	0.0

Баянцагаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,814.4	13,394.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,678.0	0.0
210604	Урсгал засвар	34,136.4	13,394.0
2107	Томилолт, зочны зардал	7,235.5	7,252.0
210702	Дотоод албан томилолт	7,235.5	7,252.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	147,946.9	15,755.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	141,275.5	10,500.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,800.0	500.0
210803	Даатгалын үйлчилгээ	562.6	591.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	99.1	269.1
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	102.0	172.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,035.0	3,564.0
210807	Газрын төлбөр	72.8	108.9
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.0	48.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	116,033.8	164,837.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	110,679.8	161,592.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,354.0	3,245.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	261,616.7	73,459.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	216,868.0	53,124.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,579.6	30,992.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	47,218.1	19,377.8
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	95,017.4	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	38,052.9	2,754.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,257.7	20,335.5
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	20,335.5
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	10,257.7	0.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	34,490.9	0.0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,490.9	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	312,569.4	837,788.7
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	188,459.5	336,256.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	188,459.5	336,256.8
2200	Дотоод эх үүсвэрээр	188,459.5	336,256.8
220001	Барилга байгууламж	154,440.5	335,656.8
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	34,019.0	600.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-188,459.5	-336,256.8
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	124,110.0	501,531.9
101	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	164,112.5	288,222.5
20	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	288,222.5	789,754.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөг/	
				Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,719,726.4	1,256,608.2	463,118.2	73.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,060,963.4	920,951.4	140,012.0	86.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,005,850.4	867,827.4	138,023.0	86.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	350,524.2	318,208.0	32,316.2	90.8
210101	Үндсэн цалин	277,646.7	265,671.4	11,975.3	95.7
210104	Урамшуулал	2,100.0	1,773.4	326.6	84.4
210105	Гэрээт ажлын хөлс	70,777.5	50,763.1	20,014.4	71.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,400.1	40,150.5	4,249.6	90.4
210201	Тэтгэврийн даатгал	30,508.6	27,873.7	2,634.9	91.4
210202	Тэтгэмжийн даатгал	3,022.5	3,067.7	-45.2	101.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,228.5	2,445.4	783.1	75.7
210204	Ажилгүйдлийн даатгал	694.9	624.6	70.3	89.9
210205	Эрүүл мэндийн даатгал	6,945.6	6,139.2	806.4	88.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	298,806.8	253,910.7	44,896.1	85.0
210301	Гэрэл, цахилгаан	20,667.4	19,569.2	1,098.2	94.7
210302	Түлш, халаалт	273,839.4	230,044.9	43,794.5	84.0
210303	Цэвэр, бохир ус	4,300.0	4,296.7	3.3	99.9
2104	Хангамж, бараа материалын зардал	70,873.9	64,820.3	6,053.6	91.5
210401	Бичиг хэрэг	4,738.8	4,512.2	226.7	95.2
210402	Тээвэр, шатахуун	33,299.8	28,000.9	5,298.9	84.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,671.3	1,457.8	213.5	87.2
210404	Ном, хэвлэл	600.0	600.0	0.0	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	30,000.0	29,649.4	350.6	98.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	564.0	600.0	-36.0	106.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,510.4	13,394.0	116.4	99.1
210604	Урсгал засвар	13,510.4	13,394.0	116.4	99.1
2107	Томилолт, зочны зардал	8,381.5	7,252.0	1,129.5	86.5
210702	Дотоод албан томилолт	8,381.5	7,252.0	1,129.5	86.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,546.5	5,254.7	291.8	94.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500.0	500.0	0.0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	600.0	591.3	8.7	98.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	272.5	269.1	3.4	98.8
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	180.0	172.7	7.3	95.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564.0	3,564.0	0.0	100.0
210807	Газрын төлбөр	130.0	108.9	21.1	83.8
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	300.0	48.7	251.3	16.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	213,807.0	164,837.1	48,969.9	77.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	210,557.0	161,592.1	48,964.9	76.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,250.0	3,245.0	5.0	99.8

Баянцагаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,061.9	40,061.9	0.0	100.0
210201	Тэтгэврийн даатгал	27,241.4	27,286.9	-45.5	100.2
210202	Тэтгэмжийн даатгал	3,205.0	3,193.7	11.3	99.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,564.2	2,555.4	8.8	99.7
210204	Ажилгүйдлийн даатгал	641.1	638.6	2.5	99.6
210205	Эрүүл мэндийн даатгал	6,410.2	6,387.3	22.9	99.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	230,097.4	209,212.0	20,885.4	90.9
210301	Гэрэл, цахилгаан	19,691.8	15,925.9	3,765.9	80.9
210302	Түлш, халаалт	207,405.6	190,853.1	16,552.5	92.0
210303	Цэвэр, бохир ус	3,000.0	2,433.0	567.0	81.1
2104	Хангамж, бараа материалын зардал	40,469.4	40,298.0	171.4	99.6
210401	Бичиг хэрэг	7,059.4	7,010.8	48.6	99.3
210402	Тээвэр, шатахуун	20,531.7	20,505.7	26.0	99.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	206.4	294.5	-88.1	142.7
210404	Ном, хэвлэл	1,488.8	1,487.0	1.8	99.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,180.0	10,000.0	180.0	98.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,003.1	1,000.0	3.1	99.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,800.0	24,619.8	180.2	99.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,800.0	8,800.0	0.0	100.0
210604	Урсгал засвар	16,000.0	15,819.8	180.2	98.9
2107	Томилолт, зочны зардал	4,252.9	4,048.0	204.9	95.2
210702	Дотоод албан томилолт	4,252.9	4,048.0	204.9	95.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,690.4	19,308.9	1,381.5	93.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,116.4	14,748.7	1,367.7	91.5
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500.0	500.0	0.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	338.0	324.2	13.8	95.9
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	172.0	172.0	0.0	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564.0	3,564.0	0.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	232,825.3	157,368.2	75,457.1	67.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	228,121.5	152,684.2	75,437.3	66.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,703.8	4,684.0	19.8	99.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,336.1	52,508.8	827.3	98.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,336.1	52,508.8	827.3	98.4
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,568.7	15,741.4	827.3	95.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	35,367.4	35,367.4	0.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,400.0	1,400.0	0.0	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	237,339.6	160,591.5	76,748.1	67.7
220001	Барилга байгууламж	237,339.6	160,591.5	76,748.1	67.7
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,206,404.5	986,100.2	220,304.3	81.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	161,902.2	0.0	161,902.2	0.0
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	161,902.2	0.0	161,902.2	0.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	811,996.6	940,555.7	-128,559.1	115.8
320001	Орон нутгийн төсвөөс	811,996.6	779,544.0	32,452.6	96.0
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	0.0	161,011.7	-161,011.7	
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	232,505.7	45,544.6	186,961.1	19.6
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,042.8	44,544.6	45,498.2	49.5
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000.0	1,000.0	0.0	100.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	141,462.9	0.0	141,462.9	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл <input type="checkbox"/>	0.0	141,462.9	-141,462.9	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл <input type="checkbox"/>	0.0	101,796.7	-101,796.7	

Баянцагаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,113.0	53,124.0	1,989.0	96.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	55,113.0	53,124.0	1,989.0	96.4
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,992.2	30,992.2	0.0	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,377.8	19,377.8	0.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,743.0	2,754.0	1,989.0	58.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	658,763.0	335,656.8	323,106.2	51.0
220001	Барилга байгууламж	658,763.0	335,656.8	323,106.2	51.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,719,726.4	1,365,047.9	354,678.5	79.4
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	409,752.1	0.0	409,752.1	0.0
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	409,752.1	0.0	409,752.1	0.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,028,258.2	1,300,005.1	-271,746.9	126.4
320001	Орон нутгийн төсвөөс	1,028,258.2	892,506.6	135,751.6	86.8
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	0.0	407,498.5	-407,498.5	
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	281,716.1	65,042.8	216,673.4	23.1
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.0	63,231.1	6,769.0	90.3
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000.0	1,811.7	-811.7	181.2
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	210,716.1	0.0	210,716.1	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	0.0	233,568.4	-233,568.4	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	0.0	342,008.1	-342,008.1	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	305,931.1	10,500.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	305,931.1	10,500.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	144,183.6	10,500.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	144,183.6	10,500.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	144,183.6	10,500.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	161,747.5	0.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	151,489.7	0.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,039.0	0.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	95,017.4	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	35,433.3	0.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,257.7	0.0
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	10,257.7	0.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	305,931.1	10,500.4
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	305,931.1	10,500.4
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	123,394.6	9,200.4
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,000.0	1,300.0
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	181,536.5	0.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянцагаан сум нь “Баянцагаанчууд бид эрүүл, чинээлэг, хөгжсөн иргэнтэй, байгальд ээлтэй хөдөө аж ахуй, байгаль орчин, аялал жуулчлал, үйлдвэрлэл үйлчилгээг цогцоор нь хөгжүүлсэн эдийн засгийн чадамжтай Амарбуянт бүсийн төв, улсын жишиг сум болно” гэсэн эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааныхаа зорилтыг тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянцагаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь 2018 онд аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсээс гаргасан "Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянцагаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,637,821.7 мянган төгрөгөөр буюу 57.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өөрчлөлт	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Хувь
А	1	2	3	4	5	6
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	865,537.2	13.7%	1,285,245.9	48.1%	419,708.8	48.5%
Мөнгөн хөрөнгө	288,222.5	4.6%	789,754.4	29.5%	501,531.9	174.0%
Авлага	280,004.2	4.4%	217,965.1	8.2%	(62,039.1)	-22.2%
Урьдчилгаа	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Бараа материал	297,310.4	4.7%	277,526.4	10.4%	(19,784.0)	-6.7%
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,445,693.7	86.3%	1,388,163.2	51.9%	(4,057,530.5)	-74.5%
Үндсэн хөрөнгө	7,862,500.4	124.6%	3,054,997.0	114.3%	(4,807,503.5)	-61.1%
Хуримтлагдсан элэгдэл	(2,416,806.7)	-38.3%	(1,666,833.8)	-62.3%	749,972.9	-31.0%
Нийт хөрөнгө	6,311,230.9	100.0%	2,673,409.2	100.0%	(3,637,821.7)	-57.6%
Өр төлбөр	23,489.1	0.4%	3,115.0	0.1%	(20,374.1)	-86.7%
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,287,741.8	99.6%	2,670,294.2	99.9%	(3,617,447.6)	-57.5%
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,311,230.9	100.0%	2,673,409.2	100.0%	(3,637,821.7)	-57.6%

Эх сурвалж: Баянцагаан сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Үндсэн хөрөнгийн данс 4,057,530.5 мянган төгрөгөөр буурсан нь боловсролын салбарын шинэчлэлтэй холбоотойгоор сургууль, цэцэрлэг, соёлын төвийн хөрөнгийг орон нутгаас улсын төсөвт шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 789,754.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 501,531.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
			Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	288,222.5	789,754.4	501,531.9
Төгрөг	288,222.5	789,754.4	501,531.9
Төрийн сангийн харилцах	288,222.5	789,754.4	501,531.9
Дүн	288,222.5	789,754.4	501,531.9

Эх сурвалж: Баянцагаан сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 789,754.4 мянган төгрөг нь Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 282,222.4 мянга, Хоршоог хөгжүүлэх сангийн дансанд 59,785.7 мянга, орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 447,746.3 мянган төгрөг байгаа нь тайлант оны татварын давсан орлого 397,940.5 мянга, төсөвт байгууллагуудын буцаан төвлөрүүлсэн 47,151.7 мянга, урд оны зарцуулагдаагүй үлдэгдэл 2654.1 мянган төгрөг байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 217,965.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 62,039.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
			Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	615.0	0.0	(615.0)
Татаас, санхүүжилтийн авлага	106,299.0	0.0	(106,299.0)

Баянцагаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Байгууллагаас авах авлага	21,000.0	10,026.5	(10,973.5)
Хувь хүмүүсээс авах авлага	11,356.3	3,115.0	(8,241.3)
Хувь хүмүүст олгосон зээл	140,734.0	204,823.6	64,089.6
Дүн	280,004.2	217,965.1	(62,039.1)

Эх сурвалж: Баянцагаан сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант онд авлага дансны үлдэгдэл буурсан шалтгаан нь өмнөх онд сумын Эрүүл мэндийн төв нь ЭМД-ын сангаас авах санхүүжилтийн авлага болох 106,299.0 мянган төгрөгийг хүлээн авч барагдуулсантай холбоотой байна.

Хүснэгт 4. Авлагын үлдэгдэл /байгууллагаар/

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Эзлэх хувь
Сум хөгжүүлэх сан	140,733.9	204,823.6	64,089.7	94.0
